


## АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ 43 ХУВИАР БУУРЧЭЭ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 300 орчим сая хүн согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас өвчин зовлонд шаналж, амь нас эрүүл мэндээрээ хохирч байгаа талаар олонтаа мэдээлж байгаа.

**Оросын Холбооны Улсын** Засгийн газар 2006 оноос хойш олон улсад хэрэгжүүлдэг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд тавих хяналтыг нэвтрүүлж, идэвхитэй шинэчлэл хийж ажилласнаар гэмт хэргийн гаралт буурчээ. Үнийн бодлого ба борлуулалтын цагийн хязгаарлалт нь согтууруулах ундааны хэрэглээ, түүний сөрөг үр дагавруудыг бодитойгоор бууруулдаг бөгөөд гэмт хэргийн түвшинд шууд хамааралтай гэж үзэн<sup>1</sup> Засгийн газраас орон нутгийн удирдлагуудад согтууруулах ундаа борлуулах цагийн хуваарь тогтоох эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар үүрэг чиглэл өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байсан бөгөөд 2011 оноос хойш улс даяар хэрэгжиж, согтууруулах ундааг 23:00–08:00 цагт кафе, бааранд худалдаалахыг хориглож, үйлчилгээний газрууд ажлын өдрүүдэд 10:00-20:00 цагт үйлчилгээ явуулдаг болсноор гэмт хэргийн гаралт буурсныг Засгийн газраас явуулж байгаа согтууруулах ундааны бодлоготой хамааралтай гэж судлаачид дүгнэжээ.<sup>2</sup>



**Зураг 1. ОХУ-ын гэмт хэргийн тоо, 100,000 хүнд ноогдохоор, 2003-2015**<sup>3</sup>

Тэгвэл хойд хөрш Оросын холбооны улс 2003 оноос эхлэн согтууруулах ундааны үнэ, татварыг үе шаттай нэмэгдүүлэх, худалдаа, үйлчилгээний газруудын ажиллах цагийн хязгаарыг тогтоох зэрэг цогц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлсний үр дүнд тус улсын иргэдийн архины хэрэглээ 2003 оноос хойш 43 хувиар буурч, хүн амын дундаж наслалт 7.7 хувиар нэмэгдэж, нас баралт 36-39 хувиар буурсан тухай Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2018 оны тайланд дурьдагдсан байна.

Тус улс саяхан орон сууцны тагтан дээр тамхи татахыг хориглосон хууль батлан гаргаснаас гадна нийтийн орон сууцны байшинд үйл ажиллагаа явуулдаг согтууруулах

<sup>1</sup> (Babor et al, 2010). Carpenter, Dobkin, 2010; Popova et al, 2009; Wilkinson et al., 2016). Babor T, Caetano R, Casswell S, Edwards G, Giesbrecht N., Graham K., Rossow I. (2010)

<sup>2</sup> (Carpenter, Dobkin, 2010; Popova et al., 2009; Wilkinson et al., 2016)

<sup>3</sup> Wilkinson C, Livingston M., Room R. (2016). Impacts of changes to trading hours of liquor licences on alcohol-related harm: a systematic review 2005–2015. Public health research & practice, Vol. 26, No. 4. Retrieved from

ундаа худалдах, үйлчлэх газруудын зөвшөөрлийг цуцалж, гэр бүл, хүний амьдарч буй орчныг согтууруулах ундаанаас ангид байлгах зорилго тавин хэрэгжүүлж байна.

Хятад улс согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлах арга хэмжээг тууштай баримталдаг бөгөөд нийт эрчүүдийн 42, эмэгтэйчүүдийнх нь 71 хувь нь архи огт хэрэглэдэггүй гэсэн судалгаа байдаг. Тус улсад төрийн байгууллагаас зохион байгуулж буй аливаа арга хэмжээн дээр архи согтууруулах ундаа хэрэглэхийг хориглодог байна.

Манай улсад 2017 онд 4012, 2018 онд 3289, энэ оны эхний 9 сард 3142 гэмт хэрэг согтуугаар үйлдэгдсэн нь нийт үйлдэгдэж байгаа гэмт хэргийн 12 ба түүнээс дээш хувийг эзэлж байгаагаас үзвэл архи согтууруулах ундааны хяналтгүй, замбараагүй худалдаа, үйлчилгээ, хэтрүүлэн хэрэглэх нь гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд шууд нөлөө үзүүлдэг нэг том суурь шалтгаан, хүчин зүйл болохыг баталж байна.

Дэлхий нийтээр согтууруулах ундааны зохисгүй хэрэглээтэй тэмцэж буй өнөө цагт Монголчууд бид ч гэсэн архи, согтууруулах ундаанаас татгалзаж амьдарч буй орчин, үр хүүхдийнхээ сургууль, цэцэрлэгийн орчим архи, согтууруулах ундаа худалдаалахыг зогсоох нь зүйтэй юм.

--ooOoo--